



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 4 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

12.ХЭЛЭЛЦСЭН нь:

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 17,540,040.00 /арван долоон сая таван зуун дөчин мянга дөчин/ төгрөгийн балансын үнэ бүхий газар эзэмших эрх, 18,000,000.00 /арван найман сая/ төгрөгийн балансын үнэ, 12,000,000.00 /арван хоёр сая/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий барилгыг Сонгинохайрхан дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэст шилжүүлэх тухай.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 17,540,040.00 /арван долоон сая таван зуун дөчин мянга дөчин/ төгрөгийн балансын үнэ бүхий газар, 18,000,000.00 /арван найман сая/ төгрөгийн балансын үнэ, 12,000,000.00 /арван хоёр сая/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий Сонгинохайрхан дүүрэг 10 дугаар хороо, Зүүнбаян уулын 22 дугаар гудамж, 1 тоот хашаанд байрлах Олон нийтэд түшиглэсэн "Хүүхэд хамгааллын төв-3" нэртэй барилгыг Нийслэлийн өмч /Сонгинохайрхан дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс/-д шилжүүлэх асуудлыг дэмжээд, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу Засгийн газар, Улсын Их Хуралд тавьж шийдвэрлүүлэхийг даалгав." гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



00003